

# “ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Энэ 2017 оны эхний хагас жилд манай компани нь 646.8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 333.0 сая төгрөгийн зардалтай, улсад 182.2 сая төгрөгийн татвар төлж, 415.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.
2. Тус компанийн нийт ажиллагсадтай 2017 онд хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгууллаа. Ажиллагсдын ажлыг дүгнэх “Ажилтны үнэлгээний хуудас”-ыг сар тутамд гаргаж, ажиллагсдын ажилд дүгнэлт хэвшлээ.
3. Өнгөрсөн хугацаанд нягтлан бодогчоор ажиллаж байсан З.Гончигсүрэн ар гэрийн шалтгаанаар өөрийн хүсэлтээр, гадаа талбайн үйлчлэгчээр ажиллаж байсан Ч.Энхбаяр нь эрүүл мэндийн шалтгааны улмаас ажлаас тус тус чөлөөлөгдсөн. Эдгээр ажилтнуудын оронд О.Энхтуяаг нягтлан бодогчоор, Н.Цогтгэрэлийг үйлчлэгчээр ажилд авсан. Манай компанид ажилладаг гэр бүлийн 2 ажилтан С.Баярхүү, О.Энхжаргал нарт шинээр орон сууц худалдан авсантай холбогдуулан орон сууцны зээлийн төлбөрт нь буцалтгүй тусламж болгон 1 сая төгрөг, мөн удаан жил ажиллаж байгаа Ц.Пүрэвсүрэн зохицуулагчийн байшингийн дулаалгын материалд 1 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус олголоо.
4. Худалдааны төвийн нийт түрээслэгчидтэй 2017 онд байгуулах түрээсийн гэрээг цаг хугацаанд нь байгуулж дуусгасан. Нийт түрээслэгчдийг даатгалд бүрэн хамруулав. Манай худалдааны төвийн бүх талбай 100 хувь түрээслэгдсэн.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2016 оны ээлжит хурлыг холбогдох журмын дагуу цаг хугацаанд нь хуралдуулж, хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг бүрэн тараасан.
6. Хөрөнгө оруулалтын шинж чанартай дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд :
  - Худалдааны төвийн А корпусын гадна фасадыг сэндвич хавтан болгож угсрах ажлыг дуусгаж, улмаар үүнтэй холбоотойгоор гарч ирсэн тохижилтын ажлуудыг гүйцэтгэж байна.
  - Худалдааны төвийн С давхарт шинээр 2 павильон хийлгэсэн.
  - Худалдааны төвийн цахилгаан түгээх дэд өртөөнд их засварын ажлыг гүйцэтгүүлсэн.
  - Худалдааны төвийн А, Б блокийн 1, 2, 3-р давхруудад галын утаа мэдрэгчүүдийг цэвэрлүүлэн, тохиргоог хийлгэж, улмаар эвдэрсэн байсан 28 утаа мэдрэгчийг шинээр сольж суурилуулсан.
  - Худалдааны төвийн ашиглагдах боломжгүй галын хорыг шинэчилж сольсон. Мөн галын аюулгүй байдлын самбарыг шинээр хийлгүүлж тавьсан.
  - Худалдааны төвийн А, Б корпусын орох гарах хаалганы дундын талбайн хана, таазыг өнгөлгөөний хавтан болгож өөрчилсөн.
7. “Би Ди Сек” болон бусад брокерын компаниас тавьсан хүсэлтийн дагуу компанийн гадны хөрөнгө оруулагч буюу хувьцаа эзэмшигчидтэй уулзалтыг тухай бүр нь хийж ирлээ.
8. Татварын байгууллагад төлөх ёстой бүх төрлийн татвараа хугацаанд нь төлж ирлээ.
9. Түрээслэгчдэд сар бүр тогтмол албан захидлаар захиргаанаас гаргаж байгаа мэдээ, мэдээллийг хүргүүлж байна.
10. Компанийн ажиллагсдыг “Байгууллагын болон хувь хүний соёл” сэдэвт сургалтанд хамруулсан. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Эрдэнэсүрэнг Монголын хөрөнгийн биржээс хувьцаат компаниудын шилдэг ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар шагнаж урамшуулсан.
11. Компанийн веб сайтыг шинэчлэх ажил хийгдээд дуусаж байна.